



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/68

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолын 3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хошой аварга, аварга малчин, хадланч, тариаланч, саальчны шагнал, урамшуулалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 19,180,250 (Арван есөн сая нэг зуун наян мянга хоёр зуун тавь) төгрөгийг аймгийн шагналын журамд нийцүүлэн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 20... оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ХӨРӨНГИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цом	17	757,500	12,877,500
2	НӨАТ			1,287,750
				14,165,250
4	Өргөмжлөл	112	33,000	3,920,000
5	Үнэмлэх	219	5000	1,095,000
Нийт дүн				19,180,250

-105,0

---oOo---